

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/043/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Бигэрчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд

Утас: 99086371 Цахим хаяг: Tserenkhand@audit.gov.mn

Аудитор: Г.Энхдэлгэр

Утас: 99002291 Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/043/НА-СТА-ТШЗ

АГУУЛГА

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Гурав. Аудитын илрүүлэлт

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02.25 № 182

танай _____ -ны № _____ -т

БИГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Н.БУЛГАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд дөрвөн арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Бигэр сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд орон нутгийн төсвөөс 991,300.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 33,775.0 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Аудитын гол асуудал

Бигэр сумын Засаг даргын Тамгын газар бичиг хэрэг, тээвэр шатахуун, томилолтын 12,141.1 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

822511000365

Бусад асуудал

Төсвийн захирагчийн сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 26 зорилт 95 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, 10 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, 85 арга хэмжээг хэрэгжүүлснээр 86.3 хувиар дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮДЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
33	АВЛАГА	106,305,353.96	93,458,925.55
335	Бусад авлага	106,305,353.96	93,458,925.55
33510	Байгууллагаас авах авлага	106,305,353.96	93,458,925.55
35	БАРАА МАТЕРИАЛ	130,223,625.20	134,033,926.20
351	Түүхий эд материал	6,000,000.00	6,000,000.00
35110	Тусгай зориулалттай материал	6,000,000.00	6,000,000.00
354	Хангамжийн материал	31,923,625.20	35,733,926.20
35410	Бичиг хэргийн материал	3,156,075.00	2,749,450.00
35420	Аж ахуйн материал	8,713,565.00	11,151,565.00
35440	Түлш, шатах тослох материал	1,187,885.20	2,956,811.20
35450	Барилгын засварын материал	8,630,000.00	8,640,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,236,100.00	10,236,100.00
35600	Мал амьтад	92,300,000.00	92,300,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	21,300,000.00	21,300,000.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	21,300,000.00	21,300,000.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	257,828,979.16	248,792,851.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,011,174,370.99	2,916,419,120.08
392	Биет хөрөнгө	2,939,706,537.66	2,845,541,286.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,726,100,032.07	1,748,090,213.89
39202	Хуримтлагдсан элэгдэл	(404,359,302.29)	(452,158,240.34)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	156,397,000.00	262,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,652,925.24)	(100,450,892.82)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,068,171.00	152,203,668.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97,548,271.39)	(104,222,564.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,929,574.72	37,986,751.07
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,358,021.12)	(22,292,083.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,131,725,655.00	2,342,203,917.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(679,595,375.09)	(1,018,119,482.10)
393	Биет бус хөрөнгө	71,467,833.33	70,877,833.29
39301	Програм хангамж	3,980,000.00	3,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,849,166.67)	(2,439,166.71)
39303	Бусад биет бус хөрөнгө	69,337,000.00	69,337,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,011,174,370.99	2,916,419,120.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,269,003,350.15	3,165,211,971.83
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	12,141,150.00
413	Өглөг	-	12,141,150.00
4136	Бусад өглөг	-	12,141,150.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,201,150.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	8,940,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	12,141,150.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,269,003,350.15	3,153,070,821.83

**Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	257,131,132.14	257,131,132.14
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	257,131,132.14	257,131,132.14
512	Хуримтлагдсан үр дүн	2,716,233,408.66	2,600,300,880.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,333,055,059.11	2,716,233,408.66
51220	Тайлант үеийн үр дүн	383,178,349.55	(115,932,528.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	295,638,809.35	295,638,809.35
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,269,003,350.15	3,153,070,821.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,269,003,350.15	3,165,211,971.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,241,178,556.00	999,515,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	283,563,556.00	8,125,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,663,254.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	277,493,557.00	6,462,346.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,069,999.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	957,615,000.00	991,390,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	957,615,000.00	991,390,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	779,935,829.00	368,010,223.93
120	Нийтлэг татварын бус орлого	779,935,829.00	368,010,223.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	778,247,829.00	367,190,223.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,688,000.00	820,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,021,114,385.00	1,367,525,823.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,624,014,167.82	1,483,458,352.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,490,890,482.59	1,328,346,105.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	651,241,817.00	660,298,314.40
210101	Үндсэн цалин	275,856,265.00	273,199,172.00
210102	Нэмэгдэл	269,767,677.00	276,890,049.00
210104	Урамшуулал	27,660,200.00	30,764,198.40
210105	Гэрээт ажлын хөлс	77,957,675.00	79,444,895.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,000,393.42	78,230,060.73
210201	Тэтгэврийн даатгал	56,480,693.42	53,144,326.73
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,900.00	6,446,028.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,903,900.00	3,325,837.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,226,000.00	3,056,132.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,259,900.00	12,257,737.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,062,990.89	29,788,133.26

**Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210301	Гэрэл, цахилгаан	5,632,990.89	7,179,852.32
210302	Түлш, халаалт	11,380,000.00	22,138,306.67
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	469,974.27
2104	Хангамж, бараа материалын зардал	32,618,397.00	18,829,585.00
210401	Бичиг хэрэг	3,613,375.00	4,920,175.00
210402	Тээвэр, шатахуун	15,467,022.00	12,378,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,488,700.00	1,070,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	35,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,049,300.00	425,500.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	11,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,045,400.00	43,000.00
210604	Урсгал засвар	11,045,400.00	43,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,560,000.00	18,910,000.00
210702	Дотоод албан томилолт	8,560,000.00	18,910,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,565,275.00	2,624,391.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	302,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	221,670.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	334,685.00	306,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131,300.00	141,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	80,000.00
210807	Газрын төлбөр	746,400.00	684,765.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,152,890.00	888,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	687,796,209.28	519,622,620.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	319,843,294.50	45,477,146.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	367,352,914.78	474,145,474.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	133,123,685.23	155,112,247.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,464,768.00	55,835,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,637,768.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,537,000.00	29,515,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,290,000.00	26,320,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,658,917.23	99,276,647.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,658,917.23	99,276,647.02
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,624,014,167.82	1,483,458,352.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	397,100,217.18	(115,932,528.32)
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,651,267.63	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	270,600.00	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,921,867.63	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(13,921,867.63)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	383,178,349.55	(115,932,528.32)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,836,262.00	1,043,697,953.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	348,221,262.00	52,307,953.96
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,657,706.00	45,845,607.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	277,493,557.00	6,462,346.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,069,999.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	957,615,000.00	991,390,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	957,615,000.00	991,390,000.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,305,836,262.00	1,043,697,953.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,294,772,070.00	1,031,497,953.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,117,466,030.81	845,049,781.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	650,987,817.00	660,298,314.40
210101	Үндсэн цалин	275,602,265.00	273,199,172.00
210102	Нэмэгдэл	269,767,677.00	276,890,049.00
210104	Урамшуулал	27,660,200.00	35,810,382.40
210105	Гэрээт ажлын хөлс	77,957,675.00	74,398,711.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,000,393.42	78,230,060.73
210201	Тэтгэврийн даатгал	56,480,693.42	53,144,326.73
210202	Тэтгэмжийн даатгал	6,129,900.00	6,446,028.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,903,900.00	3,325,837.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,226,000.00	3,056,132.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,259,900.00	12,257,737.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,062,990.89	29,788,133.26
210301	Гэрэл, цахилгаан	5,632,990.89	7,179,852.32
210302	Түлш, халаалт	11,380,000.00	22,138,306.67
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	469,974.27
2104	Хангамж, бараа материалын зардал	23,886,860.00	17,056,736.00
210401	Бичиг хэрэг	4,951,000.00	3,108,800.00
210402	Тээвэр, шатахуун	16,401,860.00	12,565,536.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,488,700.00	1,070,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	35,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,045,300.00	277,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,575,400.00	-
210604	Урсгал засвар	9,575,400.00	-
2107	Томилолт, зочны зардал	8,560,000.00	11,410,000.00
210702	Дотоод албан томилолт	8,560,000.00	11,410,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,565,275.00	2,624,391.00

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	302,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	221,670.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	334,685.00	306,556.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	131,300.00	141,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	80,000.00
210807	Газрын төлбөр	746,400.00	684,765.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,152,890.00	888,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	324,827,294.50	45,642,146.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	324,067,294.50	45,477,146.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	760,000.00	165,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	177,306,039.19	186,448,172.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,464,768.00	55,835,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,637,768.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	69,537,000.00	29,515,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,290,000.00	26,320,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	73,841,271.19	130,612,572.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,658,917.23	99,276,647.02
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	44,182,353.96	31,335,925.55
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	1,294,772,070.00	1,031,497,953.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,064,192.00	12,200,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,064,192.00	12,200,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,064,192.00	12,200,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,064,192.00	12,200,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,064,192.00	12,200,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,064,192.00)	(12,200,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,333,055,059.11	2,885,825,000.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,333,055,059.11	2,885,825,000.60

**Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

C09	Тайлант үеийн үр дүн	-	-	383,178,349.55	383,178,349.55
C10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,716,233,408.66	3,269,003,350.15
C11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,716,233,408.66	3,269,003,350.15
C13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,716,233,408.66	3,269,003,350.15
C19	Тайлант үеийн үр дүн	-	-	(115,932,528.32)	(115,932,528.32)
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	257,131,132.14	295,638,809.35	2,600,300,880.34	3,153,070,821.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Цэвэр гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	991,390,000.00	892,113,352.98	99,276,647.02	90.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	991,390,000.00	892,113,352.98	99,276,647.02	90.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	928,074,400.00	836,277,752.98	91,796,647.02	90.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	668,227,200.00	656,874,414.40	11,352,785.60	98.3
210101	Үндсэн цалин	272,607,200.00	269,775,272.00	2,831,928.00	99.0
210102	Нэмэгдэл	282,224,300.00	276,890,049.00	5,334,251.00	98.1
210104	Урамшуулал	38,173,700.00	35,810,382.40	2,363,317.60	93.8
210105	Гэрээт ажлын хөлс	75,222,000.00	74,398,711.00	823,289.00	98.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,527,400.00	78,167,511.73	5,359,888.27	93.6
210201	Тэтгэврийн даатгал	56,838,400.00	53,081,777.73	3,756,622.27	93.4
210202	Тэтгэмжийн даатгал	6,672,300.00	6,446,028.00	226,272.00	96.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,336,100.00	3,325,837.00	10,263.00	99.7
210204	Ажилгүйдлийн даатгал	3,336,100.00	3,056,132.00	279,968.00	91.6
210205	Эрүүл мэндийн даатгал	13,344,500.00	12,257,737.00	1,086,763.00	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,443,000.00	29,066,929.85	47,376,070.15	38.0
210301	Гэрэл, цахилгаан	9,800,000.00	6,458,648.91	3,341,351.09	65.9
210302	Түлш, халаалт	65,143,000.00	22,138,306.67	43,004,693.33	34.0
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	469,974.27	1,030,025.73	31.3
2104	Хангамж, бараа материалын зардал	21,988,000.00	15,189,360.00	6,798,640.00	69.1
210401	Бичиг хэрэг	4,951,000.00	3,108,800.00	1,842,200.00	62.8
210402	Тээвэр, шатахуун	13,143,000.00	10,848,160.00	2,294,840.00	82.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	920,200.00	1,079,800.00	46.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	35,200.00	64,800.00	35.2

**Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,794,000.00	277,000.00	1,517,000.00	15.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,900,000.00	-	6,900,000.00	0.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,900,000.00	-	6,900,000.00	0.0
2107	Томилолт, зочны зардал	20,846,000.00	11,410,000.00	9,436,000.00	54.7
210702	Дотоод албан томилолт	20,846,000.00	11,410,000.00	9,436,000.00	54.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,770,800.00	2,834,391.00	936,409.00	75.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	302,400.00	302,400.00	50.0
210803	Даатгалын үйлчилгээ	315,000.00	221,670.00	93,330.00	70.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	347,600.00	306,556.00	41,044.00	88.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	141,000.00	13,000.00	91.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	290,000.00	160,000.00	64.4
210807	Газрын төлбөр	746,400.00	684,765.00	61,635.00	91.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,153,000.00	888,000.00	265,000.00	77.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,372,000.00	42,735,146.00	3,636,854.00	92.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,372,000.00	42,570,146.00	2,801,854.00	93.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	165,000.00	835,000.00	16.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,315,600.00	55,835,600.00	7,480,000.00	88.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,315,600.00	55,835,600.00	7,480,000.00	88.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,515,600.00	29,515,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,800,000.00	26,320,000.00	7,480,000.00	77.9
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	991,390,000.00	892,113,352.98	99,276,647.02	90.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	991,390,000.00	892,113,352.98	99,276,647.02	90.0
132001	Орон нутгийн төсвөөс	991,390,000.00	892,113,352.98	99,276,647.02	90.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-			

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Цэвэр гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	52,307,953.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,307,953.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,972,028.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,423,900.00
210101	Үндсэн цалин	3,423,900.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,549.00
210201	Тэтгэврийн даатгал	62,549.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	721,203.41
210301	Гэрэл, цахилгаан	721,203.41
2104	Хангамж, бараа материалын зардал	1,867,376.00
210402	Тээвэр, шатахуун	1,717,376.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,897,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,897,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,335,925.55

ГАА-2026/043/НА-СТА-ТШЗ

**Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,335,925.55
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,335,925.55
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,307,953.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,307,953.96
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,845,607.96
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,462,346.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 910.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа

- **НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой:** Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг 910.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Залруулагдаагүй 73,283.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба материаллаг 11,160.3 мянган төгрөгийн зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 73,283.3 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч 1 зөвлөмж, 2 зөрчил албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 1,364.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.7-т "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.7.-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад олгосон урамшууллыг төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.3 Албан шаардлага

1. Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь Мөнгөн минж ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 2022/13 дугаартай "Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг дэвсгэрт орших Мянгын услалтын системийн засвар, шинэчлэлтийн зураг төслийн ажлын гэрээ" байгуулсан боловч одоог хүртэл гүйцэтгэгч тал гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй, захиалагч талаас гэрээний үүргийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй бөгөөд олгосон санхүүжилтийн 62,123.0 мянган төгрөгийн авлагатай нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөр үүсгэхгүй байх" 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Мөнгөн минж ХХК-тай 2022 онд "Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг дэвсгэрт орших Мянгайн услалтын системийн засвар, шинэчлэлтийн зураг төслийн ажлын гэрээ"-тэй нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажлыг гүйцэтгүүлж, санхүүгийн тайланд үүссэн авлагыг барагдуулах ажил зохион байгуулж, биелэлт ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

2. Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэргүйгээр орон нутгийн нэмэгдлийг улс төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагчдад 50.0 хувиар нэмж тооцон 9,419.5 мянган төгрөгийг олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-тай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэргүйгээр цалингийн нэмэгдэл олгодог асуудлыг таслан зогсоож, биелэлтийг ирүүлэх.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг: Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой

Нотариатын үйлчилгээг сумын Засаг даргын Тамгын газрын даргад хариуцуулж үндсэн цалингийн 20.0 хувиар тооцож 372.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-т "Нотариатч энэ хуульд зааснаас бусад үйлчилгээний хөлс, зардал болон шагнал, урамшуулал авахыг хориглоно", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндэслэлгүйгээр нэмэгдэл хөлс олгож байгаа зөрчлийг арилгаж, цаашид давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг 910.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	910.0	-	-	1	910.0	1	910.0	-	-	-	-
Дүн		1	910.0	-	-	1	910.0	1	910.0	-	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газар	Сахилгын шийтгэлтэй ажилтнуудад 1,364.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.	1	1,368.4	1	1,368.4	-	-	-	-	-	-
	Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэргүйгээр орон нутгийн нэмэгдлийг улс төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагчдад 50.0 хувиар нэмж тооцон 9,419.5 мянган төгрөгийг олгосон.	1	9,419.5			1	9,419.5	--	-	-	-

Говь-Алтай аймгийн Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

<p>Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга нь Мөнгөн минж ХХК-тай 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан 2022/13 дугаартай "Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг дэвсгэрт орших Мянгайн услалтын системийн засвар, шинэчлэлтийн зураг төслийн ажлын гэрээ" байгуулсан боловч одоог хүртэл гүйцэтгэгч тал гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй, захиалагч талаас гэрээний үүргийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй бөгөөд өгсөн санхүүжилт болох 62,123.0 мянган төгрөгийн он дамнасан авлага бүртгэлтэй байна.</p>	1	62,123.0	-	-	1	62,123.0	-	-	-	-
<p>Нотариатын үйлчилгээг сумын Засаг даргын Тамгын газрын даргад хариуцуулж үндсэн цалингийн 20.0 хувиар тооцож 372.4 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон.</p>	1	372.4	-	-	-	-	1	372.4	-	-
<p>Нийт</p>	4	73,283.3	1	1,368.4	2	71,542.5	1	372.4	-	-